



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/330
Ажлын хэсэг байгуулах тухай

Ховд

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/31 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Дуут сум чиглэлийн 60 км зам засвар, Мөнххайрхан чиглэлийн 65 км зам засвар, Дуут сумын Нарийн тошингийн модон гүүр, Мөнххайрхан сумын Хар давын болон Хөндийн амны модон гүүрүүдийн барилгын ажилд явцын хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсүх – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Балжинням – Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч

А.Энхбаяр – Дуут сумын Засаг дарга

Б.Батболд – Мөнххайрхан сумын Засаг дарга

Д.Сэргэлэн – Дуут сумын Газрын даамал

С.Оюун-Эрдэнэ – Мөнххайрхан сумын газрын даамал

Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын газрын Авто
замын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга: Ц.Сувдаа – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул
уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн
бодлого хариуцсан мэргэжилтэн

2.Дээрх ажлуудын захиалагчийн хяналтын зардлаас шатахуун, унаа, хоол,
томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
/Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3.Дуут сум чиглэлийн 60 км зам засвар, Мөнххайрхан чиглэлийн 65 км зам
засвар, Дуут сумын Нарийн тошингийн модон гүүр, Мөнххайрхан сумын Хар давын
болон Хөндийн амны модон гүүрүүдийн барилгын ажлын явцын гүйцэтгэлийг
хянан баталгаажуулах, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д
даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН